



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ДУНДГОВЬ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

48090 Дундговь аймаг,
Сайнцагаан сум, Нарлаг баг
Утас: 70-59-24-39, 70-59-22-08, 70-59-32-08
E-mail: dundgovi@audit.gov.mn

2016.11.18.

№

01/180.

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2-д заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 203 дугаар тушаалаар баталсан “Санхүүгийн тайлангийн аудитын журам”-ын 1.9, аймгийн Аудитын газрын 2016 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Гурвансайхан сумын Байгаль хамгаалах сангийн 2016 оны 3 дугаар улирлын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн завсрлын аудитаар нийт 6,263,850.00 /Зургаан сая хоёр зуун жаран гурван мянга найман зуун тавь/ төгрөгийн дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгийг байгаль хамгаалах нөхөн сэргээх санд бус, сумын Засаг дарга, Засаг даргын тамгын газрын үйл ажиллагаанд 5,263,850.00 /Таван сая хоёр зуун жаран гурван мянга найман зуун тавь/ төгрөгийн шатахууныг зориулалт бусаар зарцуулсан.

Энэ нь Засгийн газрын Тусгай сангийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т, /Энэ хуулийн 12.1-д заасан сангийн хөрөнгийг дор дурдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна: 12.2.1-12.2.10/, ЗГ-ын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх зарцуулах, тайлагнах журам”-ын 3 дугаар зүйл 3-т /Төлбөрийн орлогын хэсгийн зарцуулалт: 3.1.-3.7./, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.-д /Тусгай сангийн хөрөнгийг батлагдсан төсвөөс хэтрүүлэх, хуульд зааснаас өөр зориулалтаар ашиглах, зарцуулахыг хориглоно./ заасныг тус тус зөрчсөн байна.

2. Байгаль хамгаалах сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулж, Ахуй үйлчилгээ SSS цогцолборын халаалтын шугам солих ажлын хөлсөнд 1,000,000.00 төгрөгийг зарцуулсан.

Энэ нь Засгийн газрын 1998 оны 188 дугаар тогтоолын “Байгаль хамгаалах сан байгуулах, зарцуулах журам”-ын 3.10-т /Сангийн хөрөнгийг дор дурдсан зориулалтаар зарцуулна 3.10.1-3.10.10/ заасан заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/ Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дурмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/ Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.1-д /Төсвийг зориулалт бусаар зарцуулсан / заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

- Сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах

1101000712

2. Сангаас гарсан шатахууны зарцуулалтын тайлан гаргаж хэвших
3. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг аймгийн Аудитын газарт 2016 оны 12 дугаар сарын 10-ны дотор албан ёсоор ирүүлэхийг Гурвансайхан сумын Засаг дарга /Д.Төмөртогтох/, нягтлан бодогч /Д.Баярцэнгэл/ нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН¹: ШИНЖЭЭЧ  Ж.УГТАХБАЯР 	ЗӨВШӨӨРСӨН: ЗАСАГ ДАРГА  Д.ТӨМӨРТОГОТОХ  НЯГТЛАН БОДОГЧ  Д.БАЯРЦЭНГЭЛ 
---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хургуулна" эзж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хургуулна.